



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,  
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-11) 32-50-76  
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, <http://www.ubhealth.mn>

2019.06.17 № 2/548  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

“Эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хавсралтаар хүргүүлж байна.

Хуулийн төсөлтэй танилцан хамт олноороо хэлэлцэж, саналаа 2019 оны 06 дугаар сарын 20-ны дотор Захиргаа, төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст бичгээр болон цахимаар ирүүлнэ үү.

ОРЛОГЧ ДАРГА



Л.ЗЭНДМАА

1150500573



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019.06.12 № 3/2659  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал авах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого", "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамнаас "Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг боловсруулаад байна.

Хуулийн төслийг эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөн болон бусад зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлгээс гарсан санал, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудаас бичгээр ирүүлсэн саналд тулгуурлан дараах үндсэн чиглэлээр боловсруулан үзэл баримтлалыг батлуулсан. Үүнд:

1. Тодорхойгүй байгаа зүйл заалтыг тодорхой болгох, нэн шаардлагатай үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, бүртгэлгүй хөдөлгөөнт хүн амд харьяалал харгалзахгүй тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн урамшуулал, аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын ажилтанд олгох тэтгэмжийн асуудлыг 2021 он хүртэл хойшлуулсан заалтыг хүчингүй болгох, "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай" хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

3. Эрүүл мэндэд иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын үйл ажиллагааны уялдааг хангах зохицуулалтыг сайжруулах, хуулиар тусгайлан захиргааны хэм хэмжээний акт боловсруулах эрх олгох заалтуудыг нэмэх, томилгоотой холбоотой давхардсан заалтыг хүчингүй болгох. Хуулийн төсөлтэй танилцан саналаа 2019 оны 06 сарын 30-ны догтор ирүүлнэ үү.

Хавсралт 1: Хуулийн төслийн үзэл баримтлал

Хавсралт 2: Хуулийн төсөл

Хавсралт 3: Хуулийн төслийн танилцуулга

Хүндэтгэсэн,

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
ДАРГА  Р.ОЮУНХАНД

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

3 дугаар зүйлийн 3.1.24 дахь хэсэгт:

“3.1.23. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” гэж хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор өрхийн эрүүл мэндийн болон нэн шаардлагатай үндсэн мэргэшлийн зарим тусламж, үйлчилгээг өрх гэр, иргэн, хамт олны оролцоог ханган үзүүлэхийг хэлнэ.”

3 дугаар зүйлийн 3.1.25 дахь хэсэгт:

“3.1.24. “Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээ” гэж өвчний эмнэлзүйн эзэнэгшлээ алдсан үед эмнэлгээс гарсны дараа нэг сараас дээш хугацаанд үзүүлэх сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээг хэлнэ.”

8 дугаар зүйлийн 8.1.16 дахь хэсэгт:

“8.1.16. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.”

8 дугаар зүйлийн 8.4 дахь хэсэгт:

“8.4 Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт:

“8.5 Энэ хуулийн 8.1.16 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.”

8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт:

"8.6 Эрүүл мэндийн ажилтны ажил үүргээ гүйцэтгэх явцад гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, түүнийг таслан зогсоос арга хэмжээг авах нөхцөл, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран батална."

8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт:

"8.7. Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг олон нийтэд түшиглэсэн боловсрол, нийгмийн урт хугацааны үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн боловсрол нийгмийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална."

8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт:

"8.8. Энэ хуулийн 16.16-д заасан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бусад эрүүл мэндийн байгууллагыг улсын хэмжээнд мэргэжлийн нэгдсэн арга зүйгээр хангах чиг үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага давхцуулахгүйгээр зохицуулна."

8 дугаар зүйлийн 8.9 дахь хэсэгт:

"8.9 Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

9 дүгээр зүйлд:

9. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээ, багц, хэлбэр

9.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг аймгийн төв, хотод амбулаторийн болон гэрээр үзүүлэх хэлбэрээр, сум, тосгонд амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх, явуулын хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэрт байгаа бүртгэлтэй болон хөдөлгөөнт хүн амд харьяалал харгалзахгүй үзүүлнэ."

9.3. Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь уламжлалт анагаахын үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт арга технологитой уялдуулан тусламж үйлчилгээ үзүүлэх бөгөөд Монголын уламжлалт анагаахын нотолгоонд суурилсан арга технологийг судлан дэлгэрүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ."

9.4. Аймаг дундын бүс болон улсын хэмжээнд харьяалал харгалзахгүй үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн эмнэлэг нь үндсэн болон нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг хослуулан үзүүлж болно.

9.5. Анагаахын их сургуулийн сургалтын түшиц төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Их сургуулийн эмнэлэг гэнэ. Их сургуулийн эмнэлэг нь үндсэн мэргэшлийн зарим тусламж, үйлчилгээг хослуулан үзүүлж болно.

9.7. Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг олон нийтэд түшиглэсэн боловсрол, нийгмийн урт хугацааны үйлчилгээтэй хослуулан үзүүлж болно.

33 дугаар зүйлийн 33.3 дэх хэсэгт:

“33.3 Амьд сорьцын эмгэг эд, эс судлал болон эд, эсийн дээжид молекул, генетикийн шинжилгээ хийнэ.”

44 дүгээр зүйлийн 44.6 дэх хэсэгт:

“44.1.6 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд товлосон хугацаанд өөрийн байгууллагын ажилтныг энэ хуулийн 8.5-д заасан журмын дагуу хамруулах”

“44.1.7 Эрүүл мэндийн байгууллагаас бусад байгууллага аж ахуйн нэгжид ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааг тухайн байгууллагын хамт олны хүрээнд зохион байгуулж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс арга зүйн зөвлөмж авч, ажиллана.”

“44.1.8. Эмнэлгийн мэргэжилтэнээс үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний тухай хувь хүний нгуцтай холбоотой нотлогдоогүй мэдээ мэдээлэл шаардах, олон нийтийн сүлжээнд байршуулахыг хориглоно.”

**2 дүгээр зүйл** Эрүүл мэндийн тухай хуульд дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс бусад сум, тосгонд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байна. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь багийн эмчийн болон яаралтай тусламжийн салбартай байж болно.”

16 дугаар зүйлийн 16.10 дэх хэсэг:

“16.10.Нэгдсэн эмнэлэг нь үйлчлэх хүрээний 10 мянгаас доошгүй суурин хүн амтай сум, тосгонд 5-аас доошгүй үндсэн мэргэшлээр, аймгийн төв, дүүрэгт 7-оос доошгүй үндсэн болон зарим нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлээр, аймаг дундын бүсийн төвд 10-аас доошгүй үндсэн болон нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

33 дугаар зүйлийн 33.3 дэх хэсэгт:

“33.3.Энэ хуулийн 33.1, 33.3-д заасан эмгэг судлалын шинжилгээ хийх болон сургалт, судалгааны зорилгоор нас барагчийн цогцосыг ашиглах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн “11.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.” гэсэн заалтыг хүчингүй болгосонд тооцсугай.

**ГАРЫН ҮСЭГ**

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны ...дугаар сарын ..-ны өдрийн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын 3-д заасан эрүүл мэндийн бүх нийтийн хамралтыг нэмэгдүүлэх зорилт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах хүний эрхийг хангахын тулд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хэрэгжүүлэхийг гишүүн орнууддаа уриалж байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-д “Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах” зорилтыг тус тус тодорхойлсон.

Иймд эдгээр бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөн болон бусад зөвлөгөөн, уулзалт хэлэлцүүлгээс гарсан санал, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудаас бичгээр ирүүлсэн саналыг нэгтгэж үзээд хуулийн төслийн үзэл баримтлалыг дараах үндсэн чиглэлээр боловсруулан батлуулсан. Үүнд:

1. Тодорхойгүй байгаа зүйл заалтыг тодорхой болгох, тусламж, үйлчилгээнээс үйлчилгээний төвлөрлийг сааруулах, бүртгэлгүй хөдөлгөөнт хүн амыг тусламж, үйлчилгээнд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн урамшуулал, аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын ажилтанд олгох тэтгэмжийн асуудлыг 2021 он хүртэл хойшлуулсан заалтыг хүчингүй болгосон заалтыг хүчингүй болгож, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх
3. Эрүүл мэндэд иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын үйл ажиллагааны уялдааг хангах зохицуулалтыг сайжруулах захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хуулиар тусгайлан эрх олгох заалтуудыг нэмэх



Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судлан, хуулийн төсөлд дараах асуудлыг тусгасан. Үүнд:

## **1. Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх**

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дахь зүйлд төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, түүний удирдлага зохион байгуулалт, аймаг дахь эмнэлгийн мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллахад зориулсан тэтгэмжийг хуульчилсан. Гэвч Монгол улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй холбогдуулан эдгээр заалтыг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 2, 4 дүгээр зүйлээр 2021 он хүртэл тус тус хойшлуулсантай холбоотой удаашралтай байна. Иймд эдгээр хойшлуулсан заалтыг хүчингүй болгож, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхээр тусгасан.

## **2. “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ”-ний тодорхойлолт нэмэх санал**

Эрүүл мэндийн тухай хуульд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ”-г тодорхойлсон заалт байхгүй. Гэтэл ДЭМБ-ын 1972 оны Алма-Атагийн тунхаглалаас эхэлж, 2018 оны Астанагийн тунхаглалд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг дэмжих, өвчин эмгэгээс шалтгаалсан санхүүгийн дарамтыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн тунхагласан.

Мөн тус хуулийн 16.4-д сум тосгоны эрүүл мэндийн төв нь “өрхийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ” гэж тодорхойлсон нь алслагдсан сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт үзүүлдэг хүүхэд, мэс засал, дотор гэх мэт зарим нэн шаардлагатай үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээ орхигдож болзошгүй байна. Мөн тухайн нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэхээр тусгасан нь уул уурхай, аялал жуулчлал, отор нүүдэл гэх мэт улирлын шинж чанартай бүртгэлгүй байгаа хөдөлгөөнт хүн амд тусламж, үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Иймд манай орны хот, хөдөөгийн онцлогт нь нийцүүлэн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг тодорхойлж, бүртгэлтэй болон тухайн нутаг дэвсгэрт байгаа бүртгэлгүй хүн амд харьяалал харгалзахгүй тэгш, хүртээмжтэй үзүүлэх асуудлыг хуулиар тодорхойлох шаардлага байна. Мөн эрүүл мэндийн бус аж ахуйн нэгж байгууллагын эмчийн ажиллах чиг үүргийг хуулиар тодорхой болгож, өвчнийг эрт илрүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оролцуулахаар хуульчилна.

### **3. Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээний тодорхойлолт нэмэх санал**

Эрүүл мэндийн тухай хуульд “Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ”-г тодорхойлсон заалт байхгүй байна. Хүн амын насжилт, халдварт бус өвчний тохиолдлын тоо өсөн нэмэгдэж байгаа өнөө үед эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ дэлхий дахинд өсөн нэмэгдэж байна. Хүн амьдралынхаа талаас илүү хугацааг хэд хэдэн архаг өвчинтэй өнгөрүүлж байгаа учир дэлхий дахинаа “long term care” зэрэг эрүүл мэндийн, нийгмийн үйлчилгээний ойлголтыг авч үздэг. Архаг хууч өвчтэй, асаргаа сувилгаа, асрамж, нийгмийн үйлчилгээ шаардлагатай байгаа иргэдэд эмнэлгээс гарсны дараа эрүүл мэндийн болоод нийгмийн зарим үйлчилгээг хослуулан авах шаардлагатай байдаг.

Хуульд нэмэлт тодорхойлолт орсноор сувилахуйн төв, сэргээн засах төв, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төвд өвчтөн хэвтүүлэх, эмчилгээ үйлчилгээ хийх чиглэл, шалгуур тодорхой болсноор эмнэлгээс гарсны дараах урт хугацаанд хийгдэх шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлж, нэг талаас эмнэлгийн шаардлагагүй хэвтэлттэй холбоотой үр ашиггүй зардлыг бууруулах, нөгөө талаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний залгамж холбоо тасралтгүй байдал сайжирна.

Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээг нийгмийн үйлчилгээтэй хослуулан авах шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний бодит эрэлт хэрэгцээнд нь тохирсон цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх хуулийн үндэслэл тодорхой болж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.

### **4. Их сургуулийн эмнэлгийн статусыг хуульчлах**

Эрүүл мэндийн тухай хуульд эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын түшиц эмнэлэг болох их сургуулийн эмнэлгийн асуудлыг хуулиар тодорхойлоогүй байна. Иймд сургалтын эмнэлгийн загварыг бий болгох, сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлзүйн хосолсон үйл ажиллагааг хуулиар зохицуулах шаардлага байна.

Эрүүл мэндийн салбарт төгсөлтийн өмнөх сургалтын эмнэлзүйн дадлагыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, зарим хувийн ортой эмнэлэгт гэрээгээр хийж байна. Тухайлбал аймаг орон нутагт байгаа АШУУИС-ийн харьяа сургууль нь тухайн орон нутгийнхаа нэгдсэн эмнэлэгт эмнэлзүйн дадлагыг хийж байна. Харин сургалтын эрх бүхий ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, Орхон аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг хийж байна.

Монгол улсын Засгийн газар Япон улсын буцалтгүй тусламжаар сургалтын эмнэлгийг барьж байгуулан Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог бий болгох зорилгоор 2019 оны 6 сарын 17-нд үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Их сургуулийн эмнэлгийг хуулиар тодорхойлсноор мэргэжлийн өндөр ур чадвартай эрдэмтэн, профессор, багш, эмч, эмнэлгийн мэргэжилтний багаар ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэн, хүн амд нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, найдвартай, хүртээмжтэй үзүүлэх эрх зүйн орчин сайжирна.

**5. Эрүүл мэндийн байгууллагын статус, түүний үндсэн чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай байна.**

Эрүүл мэндийн тухай хуульд 2016 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр сум дундын эмнэлэг, уламжлалт анагаах ухааны төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, төв эмнэлэг гэсэн эрүүл мэндийн байгууллагын төрлүүд хасагдсан.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хүн амын эрэлт хэрэгцээ, бүсчлэлээс хамаарсан том жижиг эмнэлгүүд зөвхөн үндсэн мэргэшлээр “нэгдсэн эмнэлэг” хэлбэрээр ажиллах шаардлагатай болсон. Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг зөвхөн улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий байгууллагад үзүүлэхээр тодорхойлсон. Гэтэл улсын хэмжээнд арга зүйгээр хангах чиг үүрэг хүлээхгүй хэдий ч хувийн томоохон нэгдсэн эмнэлэг, эмнэлэгт Бүсийн оношилгоо эмчилгээний төвд төрөлжсөн мэргэшлийн зарим тусламж, үйлчилгээг үзүүлсээр байна.

Хуулийн одоогийн зохицуулалт нь улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ачааллыг бууруулах, нэн шаардлагатай үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн хувьд зөрчилтэй байдалд хүргэх эрсдэлтэй байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д бүсчилсэн хөгжлийн асуудлаар аймгуудыг Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүс гэж ангилсан байх бөгөөд сумдыг бүсчилж, “Сум дундын төв”-ийг эдийн засгийн орон зайн төлөвлөлтийн дагуу хөгжүүлэхээр тусгасан.

Монгол улсын алслагдмал, тархай байршил, нүүдлийн соёл иргэншил, уул уурхай аж үйлдвэрийн хөгжил дагасан суурьшил зэрэг өөрийн онцлогтой холбоотой засаг захиргааны нэгж хооронд бүсчилсэн байдлаар сум дундын хэмжээнд 39 сум дундын эмнэлэг, хөдөөгийн 6 нэгдсэн эмнэлэг ажиллаж байна. Харин аймаг дундын бүсийн хэмжээнд Засгийн газрын тогтоолоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв-5, ажиллаж, хувийн томоохон эмнэлгүүд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж байна.

Нэн шаардлагатай мэс заслын тусламж, үйлчилгээний эмнэлзүйн практикт хүний амь насыг аврах магадлал 80 хувьд хүргэхэд “алтан цаг” хэмээн тодорхойлсон хоёр

цагийн дотор тусламж, үйлчилгээг хүргэх зорилтыг олон улсад зорьж байна. Ийм учраас “Дэлхийн мэс засал-2030” зорилтод нэн шаардлагатай мэс заслын тусламж, үйлчилгээг хөгжлийн ижил төвшинтэй орнуудыг Монгол улсын хэмжээнд хүргэхээр зорилт болгон авахад манай сум дундын эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ болох мэс заслын эмч нарын хувь нэмрийг олон улсын түвшинд үнэлсэн үнэлгээ юм.

Хуульд эдгээр өөрчлөлтийг оруулснаар Монгол хүн эх срондоо ямар газар амьдарч, ажиллаж байгаагаас үл хамааран шаардлагатай үедээ эмнэлгийн нэн шаардлагатай үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээг хүргэх бодлогын залгамж холбоо хэвээр хадгалагдаж, улсын эмнэлгүүдийн ачаалал, хүлээгдэл ихтэй зарим төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний тэвлөрлийг сааруулж, иргэд зарим ачаалал ихтэй төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг орон нутагтаа авах нөхцөл бүрдэнэ.

**6. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн асуудлыг зохицуулах захиргааны хэм хэмжээ акт боловсруулах шаардлагатай байна.**

Эрүүл мэндийн тухай хуульд цахим бүртгэл мэдээллийн асуудлыг тусгасан заалт ороогүй байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14-д заасан “эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх” талаарх эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх ерөнхий бүрэн эрхийн хүрээнд одоогийн эрүүл мэндийн мэдээллийн систем зохицуулагдаж байгаа ба нарийвчлан тодорхой зохицуулсан зүйл заалт байхгүй.

Монгол улсын Засгийн газар Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй Цахим эрүүл мэнд төсөл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд эрүүл мэндийн бүртгэл, мэдээлэл солилцооны платформыг бий болгох, нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой олон дүрэм, журам, техникийн зохицуулалтын баримт бичгүүд боловсрогдон гарах бэлтгэл ажил хийгдэж байна. Тэдгээр дүрэм, журам, техникийн зохицуулалтын баримт бичгийг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн батлуулахын тулд эрх зүйн үндэслэлийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн нийтгээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг батлан мөрдүүлснээр мэдээллийн технологийн дэвшлийг эрүүл мэндийн салбарт үндэсний хэмжээнд нэвтрүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран чанартай, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.

**7. Өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах харилцааг зохицуулах захиргааны хэм хэмжээний акт боловсруулж, аж ахуйн нэгжийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.**

ДЭМБ болон олон улсын чиг хандлага нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг дэмжин, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлж, эрт оношилж, эрт эмчлэхэд чиглэж байна. Учир нь энэхүү арга хэмжээ нь хувь хүн, гэр бүл, улс орны нийгэм-эдийн засагт өвчний оношилгоо, эмчилгээний санхүүгийн өндөр дарамтаас сэргийлж, хүн амын амьдралын чанарыг уртасгах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, өвчлөлийг дунд болон урт хугацаанд бууруулах ач холбогдолтой. Энэхүү үйл ажиллагаа нь эрүүл мэндийн байгууллага, иргэн аж ахуйн нэгж, салбар дундын оролцооноос шууд хамаарах тул нийтээр дагаж мөрдөх дүрэм журмаар зохицуулах шаардлагатай байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг үр дүнтэй зохион байгуулснаар аж ахуйн нэгж байгууллага ажилтныхаа эрүүл мэндийг сайжруулж, байгууллагын хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлнэ. Хувь хүн, гэр бүлийн хувьд эрүүл мэндийн санхүүгийн дарамтаас сэргийлнэ. Эрүүл мэндийн байгууллагын хувьд оношилгоо, эмчилгээний ачаалал, өвчлөл, нас баралт буурч, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдана.

**8. Эмгэг судлалын амьд ахуйн эд эсийн шинжилгээ, нас барагчийн цогцсыг сургалт, судалгааны зорилгоор ашиглах харилцааг зохицуулах хэм хэмжээний акт батлах заалт нэмэх санал**

Эрүүл мэндийн тухай хуульд амьд сорьцын эмгэг эд, эс судлал болон эд, эсийн дээжид молекул, генетикийн шинжилгээ хийх, нас барагчийн цогцсыг сургалт судалгааны зорилгоор ашиглах гадагшаа чиглэсэн хэм хэмжээний акт боловсруулах хуулийн үндэслэл байхгүй байна. Одоогийн байдлаар “Амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээ” хийхтэй холбоотой харилцааг Эрүүл мэндийн тухай хуультай нийцүүлэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/07 дугаар тушаалаар журамлан зохицуулж байгаа боловч энэ нь иргэдийн амьд ахуйн эд, эсийн дээжид шинжилгээ хийх, дээж материалыг лабораторид илгээх, хүлээн авах, хадгалах, устгахтай холбоотой гадагш чиглэсэн харилцааг зохицуулах тул Засгийн газрын гишүүнд хэм хэмжээний актаар зохицуулах хуулийн үндэслэлийг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн 2014-2018 он анагаахын сургуулийн оюутан бүрт мэргэжлийн суурь хичээл болох хүний биеийн бүтэц зүй анатомийн хичээл ордог. Анатомийн шинжлэх ухааны 10 гаруй төрөл байдаг бөгөөд “цогцос ашиглан хүний биеийн анатомийг бодит байдлаар нь судлах сургалт” нь төгсөлтийн өмнөх сургалтад зайлшгүй шаардлагатай боловч сургалтанд ашиглах цогцос олох асуудал бараг зогсонги байдлаар орсон бөгөөд түүнийг зохицуулсан хэм хэмжээний акт үгүй байна.

Эдгээр заалтыг оруулснаар эмгэг судлалын амьд ахуйн болон нас барагчийн цогцост хийх эмгэг судлалын шинжилгээг бүрэн хамруулсан, нас барагчийн эзэнгүй цогцос"-ыг сургалтад ашиглах асуудлыг бүрэн хамруулсан гадагш чиглэсэн хэм хэмжээний актыг иж бүрэн боловсруулах хуулийн үндэслэл бий болно. Сургалтад эзэнгүй цогцосыг ашигласнаар анагаахын сургуулийн төгсөгчдийн мэдлэг, ур чадвар дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

#### **9. “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга”-ыг томилох заалтын давхардлыг арилган нэг мөр болгон шийдвэрлэх**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.8 дахь хэсэгт: Хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтныг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх; гэж Засаг даргын бүрэн эрхэд тусгасан байдаг.

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт: “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт: “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.

Харин Эрүүл мэндийн тухай хуульд 2016 оны 4 сарын 22-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэргэжлийн босго удирдлагыг бэхжүүлэх үүднээс эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа сум тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг томилоход тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газрын даргын үүрэг оролцоог нэмэгдүүлэхээр эдгээр заалтууд орсон. Гэсэн хэдий ч хуулийг хэрэгжүүлэхэд эдгээр давхардсан заалтаас үүдэн 9 аймагт ямар нэг маргаангүйгээр Сумын Засаг дарга томилж, харин 4 аймагт ялаатай байдлаар шийдвэрлэж, Сэлэнгэ аймагт хэд хэдэн маргаан үүсэж шүүхэд хандан шийдвэрлүүлснээр дагуу сумын Засаг дарга томилсон байна. Тухайлбал, Завхан аймагт 19 суманд Засаг дарга, 3 суманд ЭМГ-ын дарга томилсон байна.

Эрүүл мэндийн яам 2018 онд Төрийн албаны зөвлөлөөс Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хэрхэн хэрэглэх талаар маргаантай асуудлууд гарч байгаа тул Эрүүл мэндийн яам Улсын дээд шүүхэд хандан албан бичгээр хуулийг зөв хэрэглэх асуудлаар зөвлөмж өгөхийг хүссэн боловч тайлбар өгөх эрх зүйн боломжгүй байна гэсэн хариу ирсэн байна. Иймд энэхүү маргаантай асуудлыг нэг мөр шийдвэрлэхийн тулд хуулийн давхардлыг арилгах зайлшгүй шаардлага гарч байна.

Сум тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг Засаг дарга томилоход эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд орон нутгийн хөрөнгө оруулалтыг татах, бусад салбартай уялдаа холбоотой ажиллахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боловч Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжил арга зүйн удирдлагаар дутагдах, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улс төрийн ашиг сонирхлоос ангид тогтвортой үйл ажиллагаа явуулахад сөрөг нөлөөтэй байна.

Иймд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай, тасралтгүй, мэргэжлийн удирдлагыг хангах үүднээс Засаг дарга томилох заалтыг нь хасаж, Эрүүл мэндийн газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж томилох заалтыг хэвээр үлдээх саналтай байна.

Хуулийн заалтын давхардлыг арилгаснаар эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний удирдлага мэргэжлийн хувьд тогтвортой байж, тухайн сум орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа ДЭМБ-ын зөвлөмж болгож байгаа хэнийг ч үл орхигдуулах зарчмаар чанарын тасралтгүй хөгжлийг ханган ажиллах эрх зүйн орчин бүрдэнэ.

**10. Эмнэлгийн мэргэжилтэнээс үйлчлүүлэгчийн хувь хүний нууцлалтай холбоотой нотлогдоогүй мэдээ мэдээлэл шаардахыг хориглох заалтыг нэмж, эмнэлгийн мэргэжилтэн ажил үүргээ гүйцэтгэх явцад амь нас, аюулгүй байдлаа хамгаалуулах хууль зүйн баталгааг тодорхой болгох**

Олон нийтийн мэдээллийн сүлжээ өргөн тархсан өнөө үед эмнэлгийн мэргэжилтэнээс үйлчлүүлэгчийн хувь хүний нууцтай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээгээр цацах, улмаар эрүүл мэндийн байгууллага, эмчлэгч эмч мэргэжилтний нэр хүндэд халдах явдал цөөнгүй гарсаан байна. Мөн нийгмийн стресс бухимдал, архидан согтуурсантай холбоотой эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ гэх мэт тасгуудад эмнэлгийн мэргэжилтнийг сүрдүүлэх, хэл амаар доромжлох гэх мэт амь нас, аюулгүй байдалд заналхийлэх тохиолдол гарсаар байна.

Иймд эмнэлгийн мэргэжилтэнээс үйлчлүүлэгчийн хувь хүний нууцтай холбоотой эрүүл мэндийн байдал, оношилгоо эмчилгээний тухай нотлогдоогүй мэдээ мэдээлэл шаардахыг хориглох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед эмнэлгийн мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэх явцад амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, энэ тухай мэдээлэл авсан бол нэн даруй таслан зогсоох арга хэмжээг авах нөхцөл, журмыг цагдаагийн байгууллагатай хамтран хэм хэмжээний актыг батлан мөрдүүлэх заалт нэмэх шаардлагатай байна.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, авах эрхтэй” гэж заасан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий ассамблейгаас баталсан “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт”-д эрүүл мэндийн бүх нийтийн хамралтад хүрэх зорилтыг тодорхойлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрхийг хангахын тулд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг гишүүн орнууддаа зөвлөсөн.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна” гэж тусгасан.

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-д “Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах”, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахаар тусгагдсан.

Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д Монгол Улсыг 4 бүс болгон ангилсан байх бөгөөд сумдыг бүсчилж, “Сум дундын төв”-ийг эдийн засгийн орон зайн төлөвтөлтийн дагуу хөгжүүлэхээр тусгасан тул эрүүл мэндийн байгууллагын чиг үүргийг энэхүү бодлоготой уялдуулах нь зүйтэй байна.



## 1.2. Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль баталсантай холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуульд "эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах болон аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд 5 жил тутамд мөнгөн тэтгэмж олгох" заалтыг тусгасан боловч улсын төсөв санхүүгийн байдалтай холбогдуулан уг хуулийн үйлчлэх хугацааг 2021 он хүртэл хойшлуулсан.

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"-ын 2.4.8.2-т "төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгийг улс төрөөс хараат бус, хамтын удирдлагатай хагас бие даасан засаглалтай болгох", 2.4.3.3-д-д "нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх" зорилт дэвшүүлсэн.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дээрх хуулиудын хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн урамшууллын зардлыг тухайн байгууллагын төсөвт багтаан шийдвэрлэх, мөн аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс байнга ирүүлдэг хүсэлтийг харгалзан үзэх, орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд хооронд нийгмийн тэгш бус дэмжлэг үйлчилж байгаа зэргийг үндэслэн дээрх хуулийн заалтын үйлчлэх хугацааг өөрчлөх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тухай хуулиар сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн сумын Засаг дарга болон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын аль аль нь томилж, чөлөөлөхөөр давхардан зохицуулагдсанаас маргаан үүсч, хуулийн байгууллагад хандахад хүргэж байгаа тул уг асуудлыг оновчтой зохицуулалтыг бий болгох замаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Халдварт бус өвчлөл, хүн амын насжилттай холбоотой өсөн нэмэгдэж байгаа архаг суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд эмнэлгээс гарсны дараа үргэлжлүүлэх эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээний талаарх зохицуулалт байхгүй тул эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

Түүнчлэн эрүүл мэндийн байгууллагын төрөл тус бүрийн үндсэн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Тухайлбал, одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа сум дундын эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, орон нутгийн нэгдсэн эмнэлэг, уламжлал анагаах ухааны төвийн статус тодорхой бус байгаагаас хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний цар хүрээг дахин тодорхойлох шаардлагатай болсон.

Эрүүл мэндийн чиглэлээр иргэд, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, цахим бүртгэл, анагаахын боловсрол олгоход шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

## Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, иргэнд үйлчлэх чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах үндсэн эрхийг хангахад оршино. Хуулийн төсөл нь 3 зүйлтэй байх бөгөөд дараахь агуулгыг тусган боловсруулна.

Нэгдүгээр зүйлд Эрүүл мэндийн тухай хуульд дараахь асуудлыг нэмж тусгана.

Монгол орны хүн амын суурьшил, хүн амын шилжилт, хөдөлгөөнөөс үл хамааран эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангахтай холбоотой "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ"-ний тодорхойлолт тусгана.

Эмнэлгээс гарсны дараа архаг өвчний эмнэлзүйн эзэнэглэлд алдсан үед урт хугацаанд үзүүлэх "Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ"-г тодорхойлсон зохицуулалт тусгаж, архаг суурь өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй, эмнэлгээс гарсны дараа урт хугацаанд сэргээн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнд эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээг хослуулан үзүүлэх асуудлыг тусгана.

Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн товлолын талаарх зохицуулалтыг тусгана.

Эрүүл мэндийн цахим бүртгэл мэдээлэл солилцооны тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, техникийн зохицуулалтын баримт бичгийн талаарх зохицуулалтыг тусгана.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалт тусгана.

Эмгэг судлалын шинжилгээ хийх асуудлыг зохицуулсан амьд сорьцын эмгэг эд, эс судлал болон эд, эсийн дээжид молекул, генетикийн шинжилгээ хийх, амьд сорьцын эмгэг эд, эс судлал болон эд, эсийн дээжид молекул, генетикийн шинжилгээ хийх, заалт нэмж, эмгэг судлалын шинжилгээ хийх болон анагаах ухааны сургалт, судалгааны зорилгоор цогцос ашиглах үйл ажиллагааны талаарх зохицуулалт тусгана.

2 дугаар зүйлд Эрүүл мэндийн тухай хуулийн дараахь зохицуулалтыг өөрчлөн найруулахаар тусгана.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг тухайн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт бүртгэлтэй эсэхээс үл хамааран хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг адил тэгш үзүүлэхээр өөрчилнө.

Нийслэл, бүс, аймаг, сум, дүүрэгт ажиллаж байгаа нэгдсэн эмнэлэг болон уламжлалт анагаах ухааны эмнэлгийн үйлчлэх хүрээ, үзүүлэх тусламж, үйлчилгээг ялгаатай байхаар өөрчилнө.

Хуульд заасан төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх өрсөлдөөнийг дэмжиж төвлөрлийг сааруулах, тэдгээр тусламж, үйлчилгээг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангахын тулд бусад эрүүл мэндийн байгууллагыг арга зүйгээр хангах чиг үүргийг давхцуулахгүй байхаар өөрчлөн найруулна.

3 дугаар зүйлд хуулийн давхардлыг арилгах зорилгоор холбогдох заалтыг хасах зохицуулалтыг тусгана.

Эрүүл мэндийн тухай хуульд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн сумын Засаг дарга болон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын аль аль нь томилж, чөлөөлөхөөр давхардан зохицуулсныг хасах заалт тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний цар хүрээг тодорхойлсноор түүнийг хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүрэг, салбар дундын оролцоо тодорхой болсноор Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, авах эрх хангагдана.

Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Удирдах зөвлөлтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгосноор эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, улсын төсвийн санхүүжилтийн үр ашиг, байгууллагын хариуцлага сайжирна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг тодорхой болгосноор бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагыг дэмжих, тусламж, үйлчилгээг тасралтгүй, жигд хүргэх боломж бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Санал авах тухай

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамнаас “Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг боловсруулаад байна.

Хуулийн төслийг эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөн болон бусад зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлгээс гарсан санал, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудаас бичгээр ирүүлсэн саналд тулгуурлан дараах үндсэн чиглэлээр боловсруулан үзэл баримтлалыг батлуулсан. Үүнд:

1. Тодорхойгүй байгаа зүйл заалтыг тодорхой болгох, нэн шаардлагатай үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, бүртгэлгүй хөдөлгөөнт хүн амд харьяалал харгалзахгүй тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн урамшуулал, аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын ажилтанд олгох тэтгэмжийн асуудлыг 2021 он хүртэл хойшлуулсан заалтыг хүчингүй болгох, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

3. Эрүүл мэндэд иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг, оролцогч нэмэгдүүлэх, салбар дундын үйл ажиллагааны уялдааг хангах зохицуулалтыг сайжруулах захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хуулиар тусгайлан эрх олгох заалтуудыг нэмэх, томилгоотой холбоотой давхардсан заалтыг хүчингүй болгох.


Хуулийн төсөлтэй танилцан саналаа 2019 оны 06 сарын 30-ны дотоо ирүүлнэ үү.

Хавсралт 1: Хуулийн төслийн үзэл баримтлал


Хавсралт 2: Хуулийн төсөл

Хавсралт 3: Хуулийн төслийн танилцуулга

Хүндэтгэсэн,

БОДЛОГО, ТӨЛӨВДӨЛТИЙН ГАЗРЫН  
ДАРГА  Р.ОЮУНХАНД

Боловсруулсан

 Н.Оюунгэрэл / мэргэжилтэн/  
Огноо